

# 技能実習生の友

Ур чадварын дадлагажигчийн анд нөхөр

2022 оны 10 дугаар сар

НАМРЫН ДУГААР

## Сэдэв

Япон хүний сэтгэлийг мангагаар дамжуулан мэдэж авъя. “Японы намрыг яаж өнгөрөөх вэ”

◇ Ойр зуурын юмыг ашиглан Япон хэлний чадвараа дээшлүүлье!

◇ Японы улирлыг илэрхийлэх үг - Намрын “Улаан навч түүлт” -

Кокуго-но-мори 「あき 萩 空き」

### Мангагаар дамжуулан мэдэж авцгаая, Япон хүний сэтгэл

#### — Японы намрыг яаж өнгөрөөх вэ —



#### Урлагийн намар, спортын намар... Тэгээд, хоолны дуршил нэмэгддэг намар!

Японд намар болоход агаарын температур буурч, нар жаргах цаг ч бага багаар эртэсч, жаахан уйтгартай санагддаг боловч, моднууд өнгөө хувирган, маш үзэсгэлэнтэй байдаг. Гадаа камп хийхэд унасан навч цуглуулан түүдэг гал асааж, чихэрлэг төмс шарж идэх боломжтой газар ч байдаг. Санма загас, туулайн бөөр, лийр зэрэг нь намрын улиралд маш амттай байдаг. Спортод ч тохирсон температуртай байдаг тул, өөр өөрсдийнхөө намрыг зугаатай өнгөрөөгөөрэй.

#### “Ур чадварын дадлагажигчийн анд нөхөр” шинэчлэгдэнэ!

Шинэчлэгдсэний дараа Япон хэл дээрх хувилбарыг товхимол хэлбэрээр хүргэх ба гадаад хэл дээрх хувилбар (9 орны хэл дээр)-ыг JITCO-гийн цахим хуудаснаас ухаалаг утас зэргийг ашиглан PDF хэлбэрээр харах боломжтой. Цаашид ч ур чадварын дадлагажигч Та бүхэнд хэрэг болох мэдээллийг хүргэхийн тулд санаа сэдэж, хичээн ажиллах болно.



## Ойр зуурын юмыг ашиглан Япон хэлний чадвараа дээшлүүлье!

Амьдрал ахуйдаа хэрэг болох мэдээлэл олж авахынхаа зэрэгцээ Япон хэлний чадвараа дээшлүүлэх аргаас танилцуулъя. Сонсохсон, ярихсан, ойлгохсон гэсэн хүсэл эрмэлзлээ нандигнаж, өдөр бүр бага багаар Япон хэлээ ашиглаж байгаарай.

### ★ Эргэн тойрондоо байгаа үнэ төлбөргүй зар хуудас, мэдээллийн товхимлыг ашиглацгаая.

Супермаркет, 24 цагийн дэлгүүр, Хотын захиргааны газар, метроны буудал, шуудан, зуушны газар зэрэг газруудад тавьсан байдаг үнэ төлбөргүй зар хуудас, мэдээллийн товхимлыг харж байсан уу? Үнэ төлбөргүй зар хуудас, мэдээллийн товхимолд хямд үнэтэй бараа, байвал ач тустай барааны талаарх мэдээллээс авахуулан, тухайн бүс нутагт болох арга хэмжээ, үйлчилгээ г.м амьдрал ахуйд хэрэг болох мэдээллүүд байдаг. Мөн, Япон хүний амьдрал ахуй, зан заншил болон Япон хэлний талаар ч суралцах боломжтой. Мэдэхгүй бараа болон нийтлэл, мэдэхгүй үг байвал, компанийхаа хүмүүс, эргэн тойрныхоо хүмүүсээс зар хуудас, мэдээллийн товхимлоо харангаа асууж үзээрэй. Энэ нь ярианы сэжүүр болж, яриа өргөжин, хөгжилтэй яриа үүснэ. Япон хэлээр ярихад хараахан өөртөө итгэлгүй байгаа хүмүүс ч зар хуудас, мэдээллийн товхимол байвал ярианы эхлэл (сэжүүр) болгох боломжтой болов уу.

#### 【Супермаркет】

Хүнс болон ахуйн хэрэглээний бараа өнгөт зурагтайгаар тавигдсан байдаг. Анх удаа харж байгаа хүнсний материал болон бэлэн хачир ч байж юуны магад. Сонирхол татсан юм, гоё санагдсан юм байвал, нэг удаа авч идэж үзээрэй. Тэгээд ямар амттай байсан талаарх сэтгэгдлээ эргэн тойрныхоо хүмүүстэй ярилцаж үзээрэй.

#### 【Гэр ахуйн цахилгаан бараа】

Японы гэр ахуйн цахилгаан бараа дэлхийд алдартай. Гэр ахуйн цахилгаан барааны дэлгүүрт очвол, гэр ахуйн цахилгаан барааны зар хуудас, мэдээллийн товхимол их байдаг. Тогтмол хэрэглэдэг болон сонирхол татсан гэр ахуйн цахилгаан бараа байвал, бодитоор дэлгүүрт нь очин барааны тайлбарыг сонсож, мэдэхгүй юмаа асууж үзээрэй.



#### 【Аялал】

Аяллын зар хуудас, мэдээллийн товхимолд Японы нутаг нутгийн мэдээлэл болон газрын зураг орсон байдаг тул, Японы соёл, газар зүйн талаар суралцахад ч ашиглах боломжтой. Юуны өмнө ойрхон байгаа жуулчны газраар айлчилж, нутгийн хүмүүс, дэлгүүрийн хүмүүсээс юм асууж үзээрэй. Шинэ Японыг олж мэдэж ч магадгүй юм.

#### 【Хотын захиргааны газар, номын сан, шуудан】

Олон нийтийн үйлчилгээний газруудад ч зар хуудас, мэдээллийн товхимол байдаг. Төрөл бүрийн арга хэмжээ, хэрэг болох үйлчилгээ г.м сонирхол татах зүйлтэй таарч магадгүй. Сонирхол татахуйц арга хэмжээ байвал оролцож үзсэн ч болно биз ээ. Шинэ найзтай болох боломж болно.

Эдгээрээс гадна ч зар хуудас, мэдээллийн товхимол эргэн тойронд их байдаг. Үр дүнтэйгээр ашиглаж, Япон дахь амьдралаа зугаатай өнгөрөөхийнхөө зэрэгцээ Япон хэлний чадвараа дээшлүүлцгээе.



JITCO нь “Ур чадварын дадлагажигч гадаад иргэд, сургалтанд хамрагдагчдын Япон хэлний зохион бичлэгийн 30-р уралдаан”-ыг зохион байгуулж, шагналын эздийг JITCO-гийн цахим хуудсаар зарласан. Шилдэг бүтээлийн цомгийг ч цахим хуудсандаа жич байршуулна. Та бүхнийг сонирхон харахыг урьж байна.



## Японы улирлыг илэрхийлэх үг -Намрын “Улаан навч түүлт”-

Японд улирал улирлын онцлог гайхамшиг байдаг. Намар бол зуны халууны эрч буурч, өвөл болтол бага багаар сэрүүн болдог улирал юм. Японд “Хоолны дуршил нэмэгддэг намар”, “Спортын намар”, “Уншлагын намар” г.м үгнүүд байдагчлан, намрын идэх юм, дасгал хөдөлгөөн хийхэд тохирсон сэрүүн цаг агаар зэргээр намар болохыг тэсэн ядан хүлээдэг гэж ярьдаг хүмүүс ч олон байдаг.

Та бүхэн “Улаан навч түүлт” гэдэг үгийг өмнө нь сонсож байсан уу? Япон хэлэнд намар өнгө нь улаан болж хувирдаг улаан навчийг таашаах “Улаан навч түүлт” гэдэг үг байдаг. “Улаан навч түүлт” нь Камакурагийн үеийн Японы танка шүлэгт ч гардаг, тийм хуучнаас байсан үг. Байгаль дунд тухайн улирлын цэцэг, жимсийг хайж зугаацахдаа, хайж байгаа юмаа “---- түүлт” гэж хэлдэг байснаас гаралтай гэж үздэг ба байгаль дэлхийг тэр чигээр нь амтархан таашаах арга хэмжээ болж орчин үе хүртэл үргэлжилж байгаа соёл юм. Үүнээс гадна “Усан үзэм түүлт”, “Мөөг түүлт” г.м-ээр хэрэглэгддэг.

Өнгө нь улаан болж хувирдаг навч нь үүр цайх үеийн температур 6°C-7°C болоход өнгө нь хувирч эхэлдэг ба ойролцоогоор 20 орчим хоногийн дараа харахад хамгийн үзэсгэлэнтэй үе нь байдаг. Хаврын “Сакура цэцгийн дэлбээлэлтийн фронт” нь өмнө зүгээс хойд зүг рүү шилждэг бол, намрын “Улаан навчны фронт” нь хойд зүгээс өмнө зүг рүү шилждэг. Нэг жилийн дотор сакура цэцэг, улаан навчийг таашаах боломжтой байгаа нь ч 4 улиралтай Японы давуу тал гэж хэлж болох болов уу.

Японы улаан навчны алдартай газар гэгддэг газруудын ихэнх нь сүм хийд, Шинто шашны сүм “Жинжа” юм. Өнцөг булан бүрийг нь арчилж тордсон цэцэрлэг нь үзэсгэлэнтэй, шөнө оройн цагаар улаан навчсыг гэрэлтүүлгээр чимдэг газар ч байдаг. Мөн, дан ганц улаан навч биш, Гинкго билоба мод алтан шаргал өнгөөр өнгөө хувиргасан байдал нь ч маш үзэсгэлэнтэй ба олон хүний очих дуртай газар ч байдаг тул өөр өөрсдийнхөө “Намар”-ыг олоорой.



< Киотогийн Бишамон-до хийд >

## Кокуго-но-мори

Энэ нь Япон хэлний үг хэллэг, ханз болон эдгээрийн хэрэглэх аргын талаар суралцахад зориулсан сурах бичиг болно. Зугаатайгаар хариуг нь бодож олцгооё. (Хариу нь дараагийн хуудсанд байгаа.)

「あき 秋 空き」から選んで書きましょう。

の中の字や言葉につづくように。

あき 秋 空き



